



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 01 өдөр

Дугаар Д/275

Хэрлэн сум


Хэрлэн лаборатори нэгдүгээр сургуульд
дэмжлэг үзүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай 66 дугаар зүйлийн 66.1, Монгол хэлний тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.3, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймаг байгуулагдсаны түүхт 100 жилийн ойн хүрээнд Монгол бичгийн улсын олимпиадын гурвын давааг Чингис хотод зохион байгуулахтай холбогдуулан арга хэмжээний зардалд зориулж 3,411,000 (гурван сая дөрвөн зуун арван нэгэн мянга) төгрөгийн дэмжлэг үзүүлсүгэй.

2.Дэмжлэгт шаардлагатай хөрөнгийг Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Л.Батсайхан)-д тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ